

Г. ТУНГАЛАГЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ: ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				Эхлэх Дуусах хугацаа	Биелэл т хувь	
			Суурь түвшин	Эхний хагас	Хүрсэн түвшин биелэлт				
1	2	3	4	5	6		7	8	
МУЗГАУХ-3.4.3.3, 3.4.3.4, 3.4.3.8, 3.4.3.9, АЗДУАХ-3.11.1.1-3.11.17, БОУАӨС-№25-15 2.4-2.6, 4.3-4.11									
Зорилт-1. Орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодис, байгалийн гамшгийн талаарх хэрэгжиж буй салбарын хууль тогтоомж,тогтоол шийдвэр баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах, тайлагнах.									
1	Хариуцсан ажлын чиг үүргийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнах	Нийт шийдвэрийн тоо	22	15	Хог хаягдал орчны бохирдолтой холбогдолтой холбогдолтой хууль тогтоомж бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг Төрийн мэдээллийн сүлжээ цахим системд хууль тогтоомжийн шийдвэр -3, Аймгийн засаг даргын захирамжийн хэрэгжилт - 6 нийт 3Г-ын үйл ажиллагааны хөтөлбөр-3, ИТХ-тогтоол -1, 13 заалтыг хугацаанд нь оруулж ажилласан.				01-06
		Хугацаандаа оруулсан шийдвэрийн тоо	22	15					
		Биелэлтийн дундаж хувь	-	80					
2	Сарын тайлан, хугацаатай албан бичгийн хариуг тухай бүр нэгтгэн хүргүүлэх	Хугацаанд гарсан албан шийдвэрлэлтийн хувь	100	100	1. Ирсэн бичиг – 17 2. Шийдвэрлэж хариу өгсөн- 10 3. Давсан бичиг - 10 4. Сарын ажлын тайлан – 6 холбогдох газар болон мэргэжилтэнд хүргүүлж ажиглаа.				01-06

3	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийх төсвийг шийдвэрлэх, агаар бохирдуулагчийн эх үүсвэрийн тооллогыг УЦУОШТ-тэй хамтран зохион байгуулж тайлагнах	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоо	5486	5500	Жил бүрийн 12 дугаар сараас, дараа оны 03 сар хүртэл Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажиглалтын нутгийн хэмжээнд явагддаг. Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2024.12.02 А/676 тоот захирамжаар ажлын хэсэг томилгодож Сумдад засаг даргын захирамж ажлын төлөвлөгөөт албан бичгийн хамт хүргүүлсэн. Ажлын хэсэг тооллогын ажлыг явуулж (www.epurotol.mn.gov.mn) орчны бохирдлын эх үүсвэрийн хаягдлын тооллогын мэдээллийн санд эх үүсвэрийн хүчин чадлаар нь тоон мэдээлэл гаргаж нийт мэдээг мэдээллийн санд оруулна. 2024 онд хийгдсэн агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогын дүнээр Ердийн таллагаатай 3-15 квт хүрэлх хүчин чадалтай зуух нийт 5483 өрх, Усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай зуух аймгийн хэмжээнд 113, Баруун-Урт сумын хэмжээнд 100-4200 квт хүчин чадалтай 4 байгууллагын 16 зуух, аймгийн хэмжээнд нийт 13 сумын 17 аж ахуй нэгжийн 18 уурын зуух, 4200 квт-аас дээш хүчин чадалтай зуух 2 Баруун-Урт дулааны станц бүртгэгдсэн байна.	12	
		Сумд руу чиглэл хүргүүлсэн албан бичгийн тоо	13	13			
МУЗГҮАХ-3.4.3.3, 3.4.3.4, 3.4.3.8, 3.4.3.9, АЗДҮАХ-3.11.1.1-3.11.17, , БОУАӨС-№25-15 2.4-2.6, 4.3-4.11							
Зорилт-2 Химийн бодис , аюултай бодис , хүрээлэн буй орчны бохирдлын талаарх хэрэгжиж буй хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах.							

1	2	3	4	5		7	8
4	Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, тухайн бүсэд мөрдөх журмыг батлах	Батлагдсан шийдвэрийн тоо	-	-	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг боловсруулж БОУАӨ-ийн яаманд 2024 оын 12 сарын 30-ны А/654,930 тоот тушаал захирамжаар баталгаажиж хууль зүйн яаманд хүргүүлээд байна.	-	
5	Бүх нийтийн их цэвэрлэгээ, улсын чанартай авто зам нуур ус булаг шанд өвөлжөө хаваржааны эзэнгүй хог хаягдлын цэвэрлэгээг жилд хоёроос доошгүй удаа аймгийн хэмжээнд зохион байгуулах	Цэвэрлэсэн хогийн хэмжээ /тн/	1600	500	Аймгийн хэмжээнд хаврын бүх нийтийн нэгдсэн цэвэрлэгээг 13 удаа хийж нийт 1775 айл өрх, 481 алба хаагч 228 ААНБ хамрагдаж 943 тн хог хаягдлыг цэвэрлэж 8.3 сая төгрөг зарцуулж хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлсэн байна. -Баяндэлгэр, Онгон , Эрдэнэцагаан суманд хог хаягдлын мөнөжментийг сайжруулах зорилттой тус тус хог тээврийн машин 1 худалдан авсан бөгөөд нийт 165.5 сая төгрөг зарцуулсан байна.	03-06	
		Зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/	60.0	20.0			
		Ландфилл хийсэн сумын тоо	1	-			
6	Аймгийн хэмжээнд тухайн жилд төвлөрсөн хогийн нэгдсэн цэгийг стандартын шаардлагад нийцүүлэх талаар чигтэлийг сумдруу хүргүүлж, арга зүйгээр хангах, хяналт тавин ажиллах	Сумдын төвлөрсөн хогийн цэгийн багасгасан талбай хэмжээ га	44.5	23.8	Эрүүл ахуйн шаардлага хангасан хүн амын эрүүл мэнд, байгальд ээлтэй хогийн нэгдсэн цэгийг байгуул цэгцэлж, тохижуулах ажлыг Тайлангийн хугацаанд 7 сум хог хаягдлын төвлөрсөн цэгт тархсан 23.8 га талбай бүхий хогийг түрж цэгцэлсэн байна тус ажиглд орон нутгийн төсвөөс 14.9 сая төгрөг зарцуулж ажилласан.	03-06	
		Зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/	82.9	14.9			

					Дарьганга, Онгон сумд хотгийн нэгдсэн цэгт камержуулалтыг шинээр иргэд олон нийтийн оролцоотой болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэн хийсэн байна		
		Үзэсгэлэнд хамруулсан ААН-ын тоо	-	50	Аймгийн ЗДТГ, Байгаль орчны газар, Баруун-Урт сумын ЗДТГ хамтран Хөрс усны бохирдол, гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттай бууруулах менежментийг орон нутгийн түвшинд төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой зохион байгуулж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой “Эко жорлон-Эрүүл орчин” өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд өдөрлөг 2 үе шаттай явагдсан үүнд: 1. Нүхэн жорлонгийн өнөөгийн нөхцөл байдал, эко ариун цэврийн байгууламжийн шийдлүүд, ногоон зээлийн талаарх мэдээлэл сургалт, 2.Төв талбайд байгалыд ээлтэй стандартын шаардлага хангасан технологийн оновчтой шийдэл бүхий ариун цэврийн байгууламж эко жорлонгийн шинэ шийдэл технологиудыг олон нийтэд таниулах үзэсгэлэн - Септик систем болон бага оврын цэвэрлэх байгууламжийн шийдэл Ногоон зээлийн танилцуулга, үйлчилгээг иргэдэд нэг дор нь хүргэж ажилласан Хаан банк, Хас банк, Төрийн банк, Чулуут биндэр ХХК, Эколог алтай ХХК, Ховдтул ХХК, Био-Ундрага ХХК 7 аж ахуйн нэгж		
7	“Эко жорлон -Эрүүл орчин” жорлонтоо өөрчилье өдөрлөг зохион байгуулах	Сургалт өдөрлөгт хамрагдсан иргэдийн тоо	-	200		04-06	

					оролцож өөрийн бараа бүтээгдэхүүнээ танилцуулсан. Сургалтанд 120 гаруй иргэн ААНБ хамрагдаж эко жорлонгийн талгаар мэдээллийг авсан бол өдөрлөгийн үйл явцыг мэдээллийн сайтаар олон нийтэд дамжуулж 7400 хүний хандалт авсан байна. Өдөрлөгт оролцсон иргэдийн дунд 15ш азийн сугалаа явуулж 1 сүлжр азтан Эко нойл, 8 азтан хөрс нөхөн сэргээх ашигт бактери, 5 азтан эко жорлонгийн шийдлүүд номыг хожсон байна.		
	Сүмд руу чиглэл хүргүүлсэн албан бичгийн тоо	13	13		Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025.02.17-ны 01/837 албан бичгийн хүрээнд аймгийн Засаг даргын 2025.02.20-ны “тооллого судалгаа ирүүлэх тухай” 01/184 тоот албан бичгийг сумдад хүргүүлж Стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлонтой гэр хорооллын айл өрх- 7926, Малчин айл өрх- 6944, Төвлөрсөн системд холбогдсон айл өрх- 2979, Төрийн байгууллага - 38, Худалдаа үйлчилгээний байгууллага- 87, Шатахуун түгээх станц -22, Уул уурхай -24, Жуулчны бааз -6, Сум суурин зам дагуу 9 жорлон тоологдож, бууруулах төлөвлөгөөг баталж аймгийн Засаг даргын 2025.03.24-ний 01/273 тоот албан бичгээр харьяа төрийн		
8	Орон нутгийн хэмжээнд нүхэн жорлонгийн тооллого хийж, /ой ба усан сан, тусгай хамгаалалттай газар/, нүхэн жорлонг халах төлөвлөгөөг баталж, шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх	Зарцуулсан мөнгөн дүн /сая.төг/	113.9	-		03-06	

					захиргааны төв байгууллагад хүргүүлээд байна. Үүнтэй холбогдуулан аймгийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан баталж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Тайлант Тайлант хугацаанд нийт аймгийн хэмжээнд айл өрх, аж ах ахуйн нэгж байгууллага 64 эко ариун цэврийн байгууламжийн ажил хийгдэж байна. ОНХС-130.0 сая, хувь хөрөнгөөр 4.9 сая төгрөг зарцуулсан байна.		
		Ажлын гүйцэтгэлийн хувь	-	50%	Уур амьсгалын өөрчлөлтийн НҮБ-ийн суурь конвенц түүний Парисын хэлэлцээр, Атсын хараа 2050 Монгол улсын Засгийн газрын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын 2024-2028 үйл ажиллагааны хөтөлбөр орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах зорилттой Сүхбаатар аймгийн “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах төлөвлөгөө”-г Аймгийн Засаг даргын 2025.02.14-ны А/49 тоот захирамжаар баталсан ажлын хэсэг боловсруулж, Аймгийн ИТХ-ийн 2025 оны 04 дүгээр сарын 14 өдрийн 15 тоот тогтоолоор 14 зорилт 78 арга хэмжээг батлуулаад байна.		
9	Сүхбаатар аймгийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө боловсруулах, туршлага судлах	Батлуулсан төлөвлөгөө	-	1	Мөн “Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөний төсөлтэй танилцах, туршлага солилцох зүүн бүсийн форумыг нийт 80 орчим хүний бүрэлдэхүүнтэй	01-06	

					зохион байгуулсан. Тус форумд Дорноговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар зэрэг аймгийн төлөөлөл оролцож уур амьсгалын ногоон сангийн санхүүжилтээр Даян дэлхийн ногоон хөгжлийн институт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвтэй хамтран “Үндэсний тодорхойлсон хувь нэмрийг хэрэгжүүлэх техникийн болон тогтолцооны чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг тусгах нь” төслийг хэрэгжүүлэн ажилласан. г.м 39-н арга хэмжээ 50% хэрэгжилттэй байна.		
10	Тэг хог хаягдалд– Бидний оролцоо” сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Хамрагдсан иргэдийн тоо	120	80	“Тэг хог хаягдалд аж ахуйн нэгж байгууллагын оролцоо хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг БУЗДТГ-ы багийн ажлын албатай хамтран 1,2 дугаар багийн 10 орчим аж ахуйн нэгжид сургалт хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн эко клубын сурагчдын дунд “Хогтуй орчин- Бидний ирээдүй” өртөөчилсөн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж нийт 30 гаруй клубын гишүүдийг хамруулж ажиллаа. 2 арга хэмжээ	01-06	
		Хамрагдсан сурагчдын тоо	300	200			
		Зохион байгуулсан сургалтын тоо	2	2			
11	БОУАӨСайдын 2024.09.13-ны өдрийн 07 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах	Биелэлтийн хувь	10	40	БОУАӨСайдын 07 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажлын хүрээнд 3 зорилтын 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөө гаргаж газрын даргаар багтуулан үйл ажиллагаандаа	01-06	

					мөрдлөг болон ажиглаж байна. Мөн дээрх төлөвлөгөөтэй уялдуулан Аймгийн Засаг даргын 2025 оны №02 дугаар албан даалгавар “Шатахуун түгээх станцаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай” шийдвэрийг гаргаж сумдад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиглаж байна. 2025 оны хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувийн хэрэгжилттэй байна. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: -Аймгийн ШТС-ын жорлонгийн тооллогыг хийхэд 43 ШТС үйл ажиллагаа явуулж байгаагаас 22 шатахуун түгээх станц нь стандартын шаардлага хангаагүй уламжлалт нүхэн жорлонг ашиглаж байгаа нь нийт 50 орчим хувийг нь эзэлж байна. - Танхимын сургалт 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 55 ААНБ, 120 орчим иргэнийг хамруулсан. Мөн Эко жорлон-Эрүүл орчин өдөрлөгийг Монголын Жорлонгийн Ууган Холбоо"ТББ-тай хамтран зохион байгуулж “Хуурай технологийн эко жорлонгийн ухаалаг шийдлүүдээр” үзэсгэлэн гаргаж олон нийтэд танилцуулсан. - Түмэнцогт сумын Ник, Синчи ойл ШТС, Баяндэлгэр сумын Петровис, Байшинт-Ойл, Магнай трейд Асгат сумын Ник петровис, Баруун Урт сумын Жаст ойл Онгон сум ШТС 28 аж ахуйн нэгж хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонг буулгаж		
--	--	--	--	--	--	--	--

					эко ариун цэврийн байгууламж шинэчлэн байгуулсан. Шатахуун түгээх станцуудын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хөрсний бохирдлыг бууруулах урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусган батлуулж ажиллаж байна. - Байгаль орчны хяналтын улсын байцаагч нар төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг 13 ААН хийж хугацаатай албан шаардлага өгч ажилласан байна. - Нутаг дэвсгэрийн хэмжээнд ШТС-ууд АЦБ нь иргэд олон нийтэд нээлттэй ажиллаж хэвшсэн. - ГХБХБГ, сумдын ЗДТГ-тай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ШТС кадастрын зургийг гаргаж файл хэлбэрээр төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.		
12	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 -т заасан урамшуулал олгох шалгуур үзүүлэлт, урамшууллын хэмжээ, түүнийг олгох, санхүүжүүлэх, зарцуулах журмыг баталж мөрдүүлэх	Батлагдсан шийдвэрийн тоо / журам /	-	-	Хугацаа болоогүй	-	
13	Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2-т "Тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох гэж заасны дагуу бүх сумдын	- Шинээр батлагдсан сумын тоо -Төлөрүүлсэн мөнгөн дүн	12	1 100 -	Аймгийн хэмжээнд бүх сумд Хог хаягдлын үйлчилгээний хураамжаа тогтоож сумын ИТХ-аар тогтоож Хууль зүйн яамаар баталгаажуулсан. Үүнд:	01-09	

	ХЭМЖЭЭНД ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ТОГТООЖ, НЭГЖ ТАРИФ"-ЫГ БАТЛУУЛЖ МӨРДҮҮЛЭХ;	-зарцуулалтын хувь			Асгат сум 2023.06.26 03 тоот ХЗЯ-6313, Баяндэлгэр - 2022.01.27 А/06 ХЗЯ-5745, Онгон- 2020.12.18 10тоот, ХЗЯ-4939, Наран - 2024.02.23 02 тоот ХЗЯ-6717, Түвшинширээ-2024.04.29 05 тоот ХЗЯ- 6840, Уулбаян-2021.08.05 11 тоот ХЗЯ-5437, Халзан- 2021.05.19 02 тоот Түмэнцогт - 2024.12.27 02 тоот ХЗЯ-7057, Эрдэнэцагаан- 2025.04.18 01 шинэчлэн баталсан. Дарьганга- 2022.05.30 А/01 ХЗЯ- 6014, Сүхбаатар- 2022.09.12 А/18 Мөнххаан -2023.03.30 А/03 ХЗЯ-6205 Баруун Урт- 2013.11.22 04 тус тус батлуулж мөрдлөг болгон ажиллаж байна. Эрдэнэцагаан сум шинэчлэн батлуулаад байна. 2024 оны жилий эцэст үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлт 172481.90 төгрөг байсан бол тус оны хатас жилийн байдлаар 73930.7 сая төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.		
14	Хог хаягдлын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5-д "Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй" гэж	Эргүүлэн татах менежментийг нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоо	-	-	Хугацаа болоогүй	01-06	

	заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайд нарын хамтарсан А429/257 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулах						
15	Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгж, байгууллагыг (www.eic.mn) мэдээллийн сан үүсгэн бүртгэлжүүлж, бүртгэлийн дугаар олгох.	Бүртгэлийн дугаар олгосон тоо	8	2	БО-ны (www.eic.mn) мэдээллийн санд Аюултай хог хаягдал үүсгэгч аж ахуйн нэгжээр Дөрвөлж ХХК-д Ү-002047, АДАЭ ХХК Ү-002065 код бүртгэл хийж мэдээллийн санд оруулсан байна.	01-06	
Зорилт 3: Байгууллагын хүний нөөцийн чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах							
16	Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээг харгалзан урамшуулал зэрэг дэв олгуулах	-Урамшуулал олгосон албан хаагчийн тоо - Зэрэг дэв ахиулсан болон шинээр олгосон алба хаагчийн тоо	26 3	20 10	Төрийн захиргааны албан тушаал эрхэлж байгаа албан хаагч албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох журмын дагуу байгууллагын 14 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлж аймгийн ТАЗ-хүргүүлж Аймгийн Засаг даргын "Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв шинээр олгох, ахиулах тухай" 2025 оны 02 сарын 18 өдрийн Б/04 захирамжаар 13 албан хаагч зэрэг ахисан байна.	01-06	
17	Төрийн албан хаагчдын хувьын хэрэг тоо бүртгэлийг хөтөлж баяжуулах.	Баяжуулалт хийсэн хувийн хэргийн тоо	26	27	Хүний нөөцийн системд бүртгэлтэй 27 алба хаагчдын хувийн хэрэгт тогтмол баяжуулалт хийж байна. 3 хувийн хэрэг шинээр үүсгэж 13 хүний хувийн хэрэгт баяжуулалт хийж 27 албан хаагчийн мэдээллийн сангийн мэдээллийг хур системээс шинэчилж ажиллаа.	01-06	

18	Албан хаагчдийн албан тушаалын тодорхойлолтын батлуулах	Батлагдсан албан тушаалын тодорхойлолт тоо	8	-	Хугацаа болоогүй	-	
----	---	--	---	---	------------------	---	--

ХОЁР: МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхлэх Дуусах хугацаа	Биелэлт хувь
			Эхний хагас	Сүүлийн хагас	Хүрсэн түвшин биелэлт			
1	2	3	4	5	6	7	8	
1	Монгол бичгээр унших, бичих чадвараа нэмэгдүүлэх	Ахисан түвшин	-	Дунд	Хугацаа болоогүй	-		
2	Хог хаягдлын менежментийг сайжруулах сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдаж сургагч багш болох.	Авсан сертификат тоо	1	0	Эко сум ТББ -аас зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтанд 2025 оны 01 сард хамрагдаж амжилттай сурч сертификат албан бичиг авсан.	05		
3	БОУАӨЯ болон бус орон нутагт нутгаас зохион байгуулагдаж буй сургалтад хамрагдаж мэдлэг мэдээлгээ дээшлүүлэх.	Хамрагдсан сургалтын тоо	1	2	"Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээний төлөвлөгөөний төсөлтэй танилцах, туршилта солилцох салбар форум" 2025 оны 3 дугаар сарын 14 өдөр хамрагдсан., Төрийн албан хаагчдийн нэгдсэн зөвлөгөөн, УТХН 3.0 баримтад ХАА-н салбарын зорилт арга хэмжээний шинэчлэлт сэдэвт сургалт семинар, 2024.06.12 -13, уур амьсгалын	01-07		

					өөрчлөлт ба орон нутгийн төлөвлөлт форумд оролцож мэдлэг мэдээллээ дээшлүүлж ажигласан.		
--	--	--	--	--	---	--	--

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ БОЛОВСРУУЛСАН:

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ БОХИРДОЛ, ХИМИЙН *Оюун* (Г. ТУНИЛАГ) 2025.06.25
 БОДИС, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ
 ХАРИУЦСАН МЭРТЭЖИЛТЭ
 (Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)